



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 23 өдөр

Дугаар 01

Сэнхэр

Орон тоо, цалингийн санг баталж,
урамшлын хэмжээг тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албаны орон тоо, цалингийн санг хавсралтаар баталсугай.

2.Багийн иргэдийн Нийтийн Хурлын дарга нарт олгох урамшлын хэмжээг сард 151400 төгрөг (нэг зуун тавин нэгэн мянган дөрвөн зуун)-өөр тогтоосугай.

3.Тогтоосон үндсэн цалин, нэмэгдэл, урамшууллыг 2017 оны 01 дүгээр сараас эхлэн сар бүр олгохыг Нягтлан бодогч Б.Бадамцэцэгт зөвшөөрсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 1 дүгээр сарын
23-ны өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



МӨНХХАЙРХАН СУМЫН ИТХ-ЫН
ОРОН ТОО, ЦАЛИНГИЙН САН

№	нэрс	Албан тушаал	терийн албанд ажилласан жил	Тухайн албан тушаалд ажилласан жил	цалингийн ангилал, зэрэглэл	Үндсэн цалин	Терийн алба хаасан хугацааны нэмэгдэл хувь	Зэрэг дэвийн нэмэгдэл хувь	Онцгой нөхцлийн нэмэгдэл хувь	Нууцны нэмэгдэл	жилийн цалин
1	Я.Очир	Хурлын дарга	8	0.2	УТ	835276			30		13030306
2	О.Бишгарам	Нарийн бичгийн дарга	29	4	ТЗ-7-5	733863	25	23		20	14794678
Дүн											27824984



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 02

Сэнхэр

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.14 дэх заалтуудыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, 1 дүгээр улирлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2.Төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтэнд хяналт тавьж, улирал бүр Тэргүүлэгчдийн хуралдаанд танилцуулж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР

Мөнххайрхан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 01 дүгээр сарын 17-ний
өдрийн 02 дугаар тогтоолоор батлав.



МӨНХХАЙРХАН СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсвийн шууд захирагчийн гэрээнд тусгагдсан арга хэмжээ (гарц буюу ажил үйлчилгээ)	Тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн гүйцэтгэх ажил, үйлчилгээ /тоо, чанар/	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт		Хариуцах эзэн
		хугацаа	Хүрэх үр дүн	
1	2	3	4	5
НЭГ. "Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны үр нөлөө, өгөөжийг тогтвортой дээшлүүлнэ" гэсэн байгууллагын стратеги зорилтыг хангахад чиглэсэн ажил үйлчилгээ				
1	1.1.Сумын ИТХ-ын хуралдаан	I улирал	Төлөөлөгчдөд 14 хоногийн өмнө урилга хүргүүлж, хэлэлцэх асуудлыг холбогдох албан тушаалтнаар бэлтгүүлж 3 хоногийн өмнө төлөөлөгчдөд хүргэнэ. Хороодын хурлыг хийлгэж дүгнэлт оруулна. Зарим асуудлыг иргэний танхимаар хэлэлцүүлсэн байна. Хуралдааныг товлосон хугацаанд хийнэ.	Я.Очир О.Бишгарам
2				Б.Батболд
3				Б.Батболд Э.Эрэндаваа
4				Б.Батболд Б.Бадамцэцэг
5	1.1.2.Сумын ИТХ-ын 4 дүгээр хуралдаанаар: • Сумын төвийн мал бүхий өрхөд тавигдах шаардлага, түүнийг зохицуулах журамд өөрчлөлт оруулах тухай • Хөхнуурын амралтын газарт амрагч, жуулчдаас авах хураамжийн хэмжээг тогтоох.	II улирал		С.Мөнхтулга Б.Булганчимэг
6				Б.Батболд Э.Эрэндаваа
7				Я.Очир
				• Мөнххайрхан сумын дүрэм хэлэлцэн батлах

1

8		IY улирал	Төлөөлөгчдөд 14 хоногийн өмнө урилга хүргүүлж, хэлэлцэх асуудлыг холбогдох албан тушаалтнаар бэлтгүүлж 3 хоногийн өмнө төлөөлөгчдөд хүргэнэ. Хороодын хурлыг хийлгэж дүгнэлт оруулна. Зарим асуудлыг иргэний танхимаар хэлэлцүүлсэн байна. Хуралдааныг товлосон хугацаанд хийнэ.	Б.Батболд О.Бишгарам	
9				Я.Очир О.Бишгарам	
10				Б.Батболд	
11				Э.Эрэндаваа	
12				С.Оюун-эрдэнэ	
13	1.2. Тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэх асуудлууд	I улирал	Төлөөлөгчөөг 80-с дээш хувь биелүүлнэ.	О.Бишгарам	
14		I улирал		О.Бишгарам, Ц.Тунгалаг	
15		I улирал			
16		I улирал			
17		I улирал			Б.Батболд
18		I улирал		Б.Батболд	
19		I улирал		Ц.Ганболд	
20		II улирал		Журмын үр дүнг үнэлнэ.	Б.Түвшинзориг
21		II улирал		Тэргүүлэгчдийг мэдээллээр хангаж, тулгамдсан асуудлыг	С.Оюун-эрдэнэ
				• Сумын 90 жилийн ойн бэлтгэл ажил, хандивын бүрдүүлэлт, 90 бүтээлч ажлын явцын тухай мэдээлэл	
				1.1.3.Сумын ИТХ-ын 5 дугаар хуралдаанаар: • Сумын ИТХ-ын 2017 оны үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилтын тухай илтгэл	
				• Сумын Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, эдийн засаг, нийгмийг 2018 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай илтгэл.	
				• Сумын 2016 оны төсвийн гүйцэтгэл, 2017 оны урьдчилсан гүйцэтгэл, 2018 оны төсвийн төслийн тухай илтгэл	
				• Сумын 2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, 2018 оны төлөвлөгөөний тухай илтгэл	
				1.2.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлах	
				1.2.2.Сумын 2017 оны эрхзүйн ажлын нэгдсэн төлөвлөгөө батлах.	
				1.2.3.Суманд 2017 онд хийх хяналт, шалгалтын нэгдсэн төлөвлөгөө батлах	
				1.2.4.Сумын Иргэний танхимын нийтийн хэлэлцүүлгийн 2017 оны төлөвлөгөө батлах.	
				1.2.5.Сумын 90 жилийн ойг удирдан зохион байгуулах ажлын хэсэг, салбар комисс байгуулах	
				1.2.6.Сумын 90 жилийн ой тэмдэглэх тов тогтоож зарлах, аймагт санал уламжлах	
				1.2.7.Сумын 90 жилийн ойг угтсан 90 бүтээлч ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах.	
				1.2.8."Иргэдээс сургуулийн спорт заал ашигласны төлбөр хураамж авах, түүнийг зарцуулах, тайлагнах журам"-ын хэрэгжилт, үр дүнг хэлэлцэх.	
				1.2.9.Газрын харилцаа, газар зохион байгуулалт, газар эзэмшилт, ашиглалт, өмчлөлийн талаар хийсэн ажлын мэдээлэл	

2

22		1.2.10.ХАА-н салбарын бодлогын хэрэгжилт, малыг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаар авч буй арга хэмжээ, үр дүнгийн тухай мэдээлэл	III улирал	тодорхойлж, цаашид хийх ажлын чиглэл өгнө	Б.Ганбат
23		1.2.11.Сумын хэмжээнд нийгмийн даг журмыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх талаар хийж буй ажлын мэдээлэл хэлэлцэх.	II улирал		Н.Түвшинтөр С.Адилбек
24		1.2.12.Төсөвт байгууллагуудын үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах тухай асуудлыг шийдвэрлэх, санал уламжлах.	I, IV улирал	Тэргүүлэгчдийн хуралдаанаар зөвшөөрсөн байх	О.Бишгарам Нягтлан бодогч нар
25		1.2.13.Сумын "Залуу малчдыг малжуулах сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах журам"-ын хэрэгжилт, эргэн төлөлт, үр дүнг хэлэлцэж, журамд өөрчлөлт оруулж шинэчлэн батлах.	II улирал	Журмын өөрчлөлтийг хяналтанд авч, хэрэгжилтийн тооцно	Б.Ганбат В.Батчулуун
26		1.2.14.Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт, төслийн хэрэгжилт үр дүнгийн тухай хэлэлцэх	III улирал	Тэргүүлэгчдийг мэдээллээр хангаж, цаашид хийх ажлын чиглэл гаргаж, үр дүнг тооцно.	Б.Батболд А.Эрдэнэтуул
27		1.2.15.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилт, явцын тухай хэлэлцэх.	II улирал		Б.Батболд Э.Эрэндаваа
28		1.2.16."Соёлын төвд үйл ажиллагаа явуулахад шимтгэл хураамж тооцож авах журам"-д өөрчлөлт оруулан шинэчлэн батлах	I улирал	Журмын өөрчлөлтийг хяналтанд авч, хэрэгжилтийн тооцно	Х.Мягмаржав
29		1.2.17.Сумын хэмжээнд нийтээр дагаж мөрдөж байгаа журмын ач холбогдол, үр дүнгийн талаар хэлэлцэх, цаашид мөрдөх эсэх талаар шийдвэрлэх.	II улирал	Үр дүнг үнэлж, зарим журмыг хүчингүй болгоно	О.Бишгарам Ц.Тунгалаг
30		1.2.18.Сумын амьжиргаа дэмжих зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах.	I улирал		Б.Батболд О.Алтансүвд
31		1.2.19.Сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах	II улирал		О.Бишгарам
32		1.2.20.Сум хөгжүүлэх сангийн төсөл сонгон шалгаруулах зөвлөл шинэчлэн байгуулах.	II улирал		Б.Батболд А.Эрдэнэтуул
33		1.2.21.Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт, зээлийн ашиглалт, эргэн төлөлтөд хяналт тавих зөвлөл шинэчлэн байгуулах.	II улирал	Хуулийн хүрээнд бүрэлдэхүүнийг оновчтой байгуулна.	Б.Батболд А.Эрдэнэтуул
34		1.2.22.Сумын Иргэний танхимын төлөөллийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах	I улирал		О.Бишгарам, Ц.Тунгалаг

3

35		1.2.23.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зөвлөлийг шинэчлэн байгуулах	II улирал		О.Алтансүвд
36		1.2.24.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сумын салбар зөвлөлийг шинэчлэн байгуулах.	I улирал		Я.Очир
37		1.2.25.Мөнххайрхан сумын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах.	II улирал	Хуулийн хүрээнд бүрэлдэхүүнийг оновчтой байгуулна.	Б.Батболд
38		1.2.26.Сумын Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах салбар нийгэмлэгийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулах	II улирал		О.Бишгарам
39		1.2.27.Сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2018 оны үндсэн чиглэлийн төсөл, Орон нутгийн төсвийн 2018 оны төсөл, 2019-2020 оны дунд хугацааны төсвийн төсөөлөл хэлэлцэх	III улирал	Хугацаанд нь хэлэлцүүлж, төсвийн төсөлд санал өгнө.	Б.Батболд Э.Эрэндаваа
40		1.2.28."Эхийн алдар" одонгийн тодорхойлолт хэлэлцэж дэмжих	I улирал	Хугацаанд нь хүргүүлнэ.	Багуудын засаг дарга нар
41		1.2.29.Улс, Аймаг, Сумын сайн малчны тодорхойлолтыг хэлэлцэнэ.	I, IV улирал	Хугацаанд нь хэлэлцүүлж шалгаруулна.	Сум, багийн засаг дарга нар
42		1.2.30.Төрийн дээд шагналд тодорхойлох тухай асуудлыг хэлэлцэн уламжлах	Тухай бүр	Хугацаанд нь хэлэлцүүлж уламжилна.	Сум, багийн Засаг дарга нар
43	1.3. Хороод	1.3.1.Хороодын ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах.	I улирал	Төлөвлөгөөг 60-аас дээш хувиар биелүүлнэ.	Хороодын дарга нар
44		1.3.2.Сумын ИТХ-ын хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангах, хариуцсан ажлын чиглэлээр Хороо бүр улирал тутам 1-ээс доошгүй ажлыг санаачлан хийж хэрэгжүүлнэ.	Улирал бүр	Хороодын үйл ажиллагаа сайжирч тогтмолжсон байна.	
45		1.3.3.Сумын ИТХ-ын хуралдаанаар хэлэлцэж буй асуудлуудыг холбогдох Хорооны хурлаар хэлэлцэх, дүгнэлт гаргах	тухай бүр	Дүгнэлтийг хуралдаанд танилцуулна.	
46		1.3.4.Хороодын бүрэлдэхүүнд эрх зүйн сургалт зохион байгуулах	II улирал	Хийх ажил үргийг тодорхой болгож, чадавхжуулна.	
47	1.4. Төлөөлөгчдийн өдөр зохион байгуулах	1.4.1.Эрүүл мэнд, боловсрол, соёл, байгаль орчны чиглэлээр батлагдан хэрэгжиж байгаа төсөл, хөтөлбөрүүдийн үр дүнгийн тухай мэдээлэл хэлэлцэх	II, III улирал	Үр дүнг үнэлнэ. Мэдээллээр хангана.	Байгууллагын дарга нар
48		1.4.2.Сумын 90 жилийн ойн хүрээнд ИТХ-ын төлөөлөгчид бүтээлч ажил санаачлан хийнэ.	II улирал	Төлөөлөгчид бүрэн оролцож чанартай гүйцэтгэнэ.	Я.Очир О.Бишгарам

4

49		1.4.3.Сумын 90 жилийн ойн хандив, төсвийн зарцуулалтын тайлан, ой зохион байгуулсан тухай илтгэл хэлэлцэнэ.	III улирал	Мэдээллээр хангаж, үр дүнг үнэлнэ.	Б.Батболд Ойн ажлын хэсэг
50		1.4.4.Төлөөлөгчдийн өдөрлөгийг хууль, хяналтын байгууллагуудтай хамтран зохион байгуулж, иргэдэд хууль эрхзүйн сургалт хийж, мэдээллээр хангаж, тэмцээн уралдаан, соёлын арга хэмжээ зохион байгуулах.	III улирал	Шинэ санаа, арга туршлага нэвтрүүлнэ. Төлөөлөгчдийн идэвх оролцоо нэмэгдэнэ.	Я.Очир О.Бишгарам Аймгийн цагдаа, прокурор, шүүх
51		1.4.5.Улсын тэргүүний сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн нөхөрсөг уулзалт-тэмцээнийг зохион байгуулж, харилцан туршлага судлах.	II улирал		Я.Очир О.Бишгарам
52	1.5.Баг, байгууллага, ТББ-ын хамтын ажиллагаа	1.5.1.Багуудын ИНХ зохион байгуулж, зохион байгуулалтын асуудал хэлэлцүүлнэ.	I улирал	Товлосон хугацаанд хийж, ИНХ-ын дарга, Тэргүүлэгч, Засаг дарга нарыг шинээр сонгоно.	Багуудын ИНХ-ын дарга нар
53		1.5.2.Багуудын ИНХ-ын дарга нарын ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч бүх талаар дэмжлэг үзүүлнэ.	2017 онд	Ажлын ерөө тохижуулж ширээ сандал, сейфтэй болгоно.	Я.Очир О.Бишгарам
54		1.5.3.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмж, үйл ажиллагааны тухай мэдээллийг багуудын ИНХ-аар хэлэлцүүлэх.	III улирал	Иргэдийг мэдээллээр хангаж, ажилд нь үнэнэлт өгнө.	Д.Энхбулган
55		1.5.4.Сумын 90 жилийн ойн хандив, төсвийн зарцуулалтын тайлан, ой зохион байгуулсан тухай мэдээлэх	III улирал	Мэдээллээр хангаж, үр дүнг үнэлнэ.	Б.Батболд Ойн ажлын хэсэг
56		1.5.5.Хүмүүнлэгийн үйлс бүтээхэд оролцож "Нэг төлөөлөгч 1 хүүхэд" аян өрнүүлнэ.	2017 онд	Эмзэг бүлгийн хүүхдэд тусламж үзүүлнэ.	Я.Очир
57		1.5.6.Сумын Эмэгтэйчүүдийн байгууллагатай хамтарч чуулга уулзалтыг хамтран зохион байгуулж, алдарт ээжүүдийн алдар тэмдэглэж хүндэтгэл үзүүлнэ.	I улирал		О.Бишгарам
58		1.5.7.Хэлмэгдэгсдийн өдрөөр ном хурах, зул өргөх үйлийг Дашчойнохорлон сүмтэй хамтран хийж, сургалт сурталчилгаа, хэлэлцүүлэг хийнэ.	IY улирал	ТББ-ын хамтын ажиллагаа дээшилж, иргэдийн оролцоо нэмэгдэнэ.	Я.Очир О.Бишгарам
59		1.5.8.Ахмадын өдрөөр "дуулах өдөр" зохион байгуулж хамтран тэмдэглэж, ахмадуудад хүндэтгэл үзүүлнэ.	IY улирал		О.Бишгарам Б.Нямаа
60		1.6.Хяналт шалгалтын Ажиллагаа	1.6.1.Төсөвт албан байгууллагуудын өөрийн орлогын бүрдүүлэлт, зарцуулалтын байдалд хяналт шалгалт хийх.	II улирал	Удирдамжийн дагуу хяналт шалгалт хийж, дүнг Тэргүүлэгчид, иргэд, албан

5

61	1.7.Сургалт сурталчилгаа, мэдээлэл	1.6.2.Сумын Соёлын төвийн ном, музейн үзмэрийг тоолж, хяналт шалгалт хийж, дүнг Тэргүүлэгчдэд танилцуулах.	II улирал	тушаалтанд мэдээлж, илэрсэн зөрчлийг арилгуулна.	Тэргүүлэгчид, Өмч хамгаалах зөвлөл
62		1.6.3.Хүнс худалдаалдаг дэлгүүр, хүнс үйлдвэрлэдэг иргэн, АА-н нэгж, гал тогоо бүхий газруудад хяналт шалгалт хийнэ.	Улиралд 1 удаа		Б.Ганбат, О.Бишгарам
63		1.5.4.Засаг даргын Тамгын газарт "Нутгийн удирдлагын ордон"-ы тохижилтонд зориулж иргэдээс өгсөн хандивын зарцуулалтанд хяналт хийнэ.	I улирал		Тэргүүлэгчид, хороод
64		1.5.5.Газар эзэмшиж ашиглаж байгаа ААНБ, иргэдийн газар эзэмших гэрээнд хяналт хийнэ.	IY улирал		Тэргүүлэгчид, хороод
65		1.5.6.Хүнсний эрхийн бичгээр үйлчилж байгаа дэлгүүрт хяналт шалгалт хийнэ.	Улирал бүр		Хороод, О.Алтансүвд
66		1.5.7.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэж буй ажлууд, сумын хөгжүүлэх сангийн зээлийн хэрэгжилтэнд хяналт хийнэ.	IY улирал		Тэргүүлэгчид, хороод
67		1.6.1.Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг чадавжуулах болон манлайллын сургалт зохион байгуулна.	I улирал		О.Бишгарам Ц.Тунгалаг
68		1.6.2.Багийн ИНХ-ын дарга, тэргүүлэгчид, багийн Засаг дарга нарыг чадавжуулах сургалт зохион байгуулах	I улирал	Оролцогчдыг бүрэн хамруулж, хууль эрхзүйн мэдлэг олгоно.	О.Бишгарам Ц.Тунгалаг
69		1.6.3.Төрийн албан хаагчдад албан хэрэг хөтлөлтийн талаар сургалт зохион байгуулна.	II улиралд		О.Бишгарам Д.Тунгалаг
70		1.6.4.Өмчийн харилцааны талаар албан байгууллагын дарга, нягтлан бодогч, нярав нарт сургалт зохион байгуулна.	II улиралд		О.Бишгарам Б.Бадамцэцэг
71		1.6.5.Сумын ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын тогтоол, шийдвэрийн эмхтгэл бэлтгэж Төлөөлөгчид, баг, байгууллагуудад хургуулна.	Улирал бүр	Эмхтгэлийг шуурхай хургэнэ.	О.Бишгарам
72		1.6.6.Сумын ИТХ-ын нээлттэй мэдээллийн самбарт шинэ мэдээ мэдээлэл, хурлаас гарсан тогтоол шийдвэр, төсвийн гүйцэтгэлийг тогтмол тавьж сурталчилна.	Тухай бүр тогтмол	Мэдээллийг үнэн зөв, шуурхай ил тод сурталчилна.	О.Бишгарам Б.Бадамцэцэг
73		1.6.7.Сумын ИТХ-ын Төлөөлөгчдийг улирал бүр тойрогт нь ажиллуулж, хууль тогтоомж, хурлын шийдвэрийг сурталчилан таниулах, иргэд сонгогчидтой уулзалт зохион байгуулах	Улирал бүр	Ажиллах удирдамж гаргана. Тойрог бүрт ээлж дараагаар явуулна.	Я.Очир О.Бишгарам
74		1.6.8."Авлигын эсрэг" хууль сурталчилсан дэвжээ тэмцээнийг баг, албан байгууллагуудын дунд зохион байгуулна.	IY улиралд	Иргэдийн эрхзүйн мэдлэг дээшилнэ.	О.Бишгарам Б.Сэргэлэн

10

75	1.8. Сонгууль зохион байгуулах	1.7.1. Сонгуулийн хэсэг байгуулж, төвийн зарлана.	I улиралд	Хуулийн хугацаанд будлиан маргаангүй шударга зохион байгуулж, дүнг шуурхай мэдээлнэ.	Тэргүүлэгчид
76		1.7.2. Сонгуулийн хороо, хэсгийн хороонд ажиллах төрийн албан хаагчдын судалгааг гарган хүргүүлж, мэдээллийн сан бүрдүүлнэ.	I улиралд		
77		1.7.3. Сонгуулийн сурталчилгааны байршил тогтоож мөрдүүлнэ.	I улиралд		
78		1.7.4. Ерөнхийлөгчийн сонгуулийн бэлтгэл ажлыг хангаж, сонгууль зохион байгуулахад бүх талаар дэмжлэг үзүүлнэ.	II улиралд		
79	1.9. Өмч хөрөнгийн талаар	1.8.1. Сумын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2017 оны ажлын төлөвлөгөө батлан хэрэгжүүлнэ.	I улирал	80-аас дээш хувь биелүүлнэ.	О. Бишгарам
80		1.8.2. ХАА, МАА, газар тариалангийн чиглэлээр малчдын бүлэг нөхөрлөлд ашиглагдаж байгаа хадлангийн талбай, тугалын хашааг балансаас балансад шилжүүлэх асуудлыг дээд байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх.	II улиралд	Хууль, журмын дагуу баримтыг бүрэн бүрдүүлж, зохих шатны байгууллагын шийдвэр гаргуулна.	О. Бишгарам Б. Бадамцэцэг
81		1.8.3. Сумын хэмжээнд ашиглагдахгүй байгаа хуучин халуун усны барилга, конторын, моторын байр зэрэг объектуудыг актлах, худалдах асуудлыг дээд байгууллагад уламжилж шийдвэрлүүлэх.	III улиралд		О. Бишгарам Б. Бадамцэцэг
82		1.8.4. УЦС, Амралтын газар, багуудын өмч хөрөнгөд хяналтын тооллого хийж харуул хамгаалалыг сайжруулах арга хэмжээ авах.	III улиралд	Өмчийн хадгалалт сайжирна.	Тэргүүлэгчид, О. Бишгарам
83		1.8.5. Төрийн болон орон нутгийн өмчийн 2017 оны жилийн эцсийн тооллого зохион байгуулж, тооллогын дүнг хэлэлцэнэ.	IV улирал	Хугацаанд нь чанартай хийнэ.	Өмч хамгаалах зөвлөл, О. Бишгарам
ХОЁР ДОТООД АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ					
84	2.1.	Ажлын албаны орон тоо, цалингийн санг батлах	I улирал	Төсвийн өргүй ажиллана.	Тэргүүлэгчид, ажлын алба
85	2.2.	Төсвийн шууд захирагчийн 2017 оны үр дүнгийн гэрээ байгуулан, биелэлтийг тооцож оны эцэст дүгнүүлэх	I улирал	Гэрээг хугацаанд нь байгуулж, 80-с дээш хувь биелүүлнэ.	Ажлын алба
86	2.3.	Хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, тайлагнах, мэдээлэх, цахим системд шилжүүлэх хадгалах	I улирал	Хугацаанд нь хүлээлгэж өгнө.	О. Бишгарам
87	2.4.	Хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарт сургалт зохион байгуулах	I улирал	Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомж судлуулах	О. Бишгарам

11

88	2.5.	Албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн талаар мэдээлэл авахыг хуссан иргэдэд зохих журмын дагуу мэдээлэл олгох	Тухай бүр	Хууль, журмыг мөрдлөг болгоно	О. Бишгарам
89	2.6.	Шинээр томилогдсон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргагч нарын урьдчилсан мэдүүлэг гаргуулан, дээд байгууллагаар хянуулах	Тухай бүр	Хуулийн хугацаанд хянуулсан байна.	О. Бишгарам
90	2.7.	Ашиг сонирхлын зөрчил үүссэн тухай мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргуулан авч бүртгэх.	Тухай бүр	Бүртгэл хөтөлж, тайлбар мэдэгдлийг хадгална	О. Бишгарам
91	2.8.	Сумын ИТХ-аас баталсан захиргааны хэм хэмжээний актуудыг хянуулж улсын бүртгэлд бүртгүүлэх арга хэмжээ авах	2017 онд	Нийтээр дагаж мөрдөж буй эрхзүйн актууд бүрэн бүртгэгдсэн байх	О. Бишгарам Ц. Тунгалаг
92	2.9.	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн ажлыг удирдлагаар хангаж, тусгай төлөвлөгөөтэй ажиллуулах	I улирал	Баталсан төлөвлөгөө 80-с дээш хувь	Я. Очир
93	2.10.	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгийг удирдлагаар хангаж, тусгай ажлын төлөвлөгөөтэй ажиллуулах	II улирал	Төлөвлөгөө 80-с дээш хувь	О. Бишгарам
94	2.11.	Сумын ИТХ-ын 2018-2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2018 оны төсвийн төсөлд санал авч боловсруулах.	III улирал	Хөтөлбөрт суурилж төлөвлөнө.	О. Бишгарам Б. Бадамцэцэг
95	2.12.	Үндсэн хуулийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах.	I улирал	Хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.	Я. Очир О. Бишгарам
96	2.13.	Хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх.	III улирал	Хөтөлбөр гарган хэрэгжүүлнэ.	Тэргүүлэгчид, Ажлын алба
97	2.14.	Сумын ИТХ-ын 2017 оны хөтөлх хэргийн нэрийн жагсаалт боловсруулан батлуулж, оны эцэст архивын баримтыг үдэж данс бүртгэл үйлдэж сумын архивт хүлээлгэн өгөх.	I улирал	Баримтын бүрдэл хангасан байна.	О. Бишгарам
98	2.15.	Иргэдийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, уламжлах, хариу мэдэгдэх.	Тухай бүр	Хуулийн хугацаанд хариу хүргүүлнэ.	Я. Очир О. Бишгарам
99	2.16.	Сумын ИТХ-ын төсвийн 2017 оны жилийн эцэс, 2017 оны I, II, III улирлын санхүүгийн тайланг гаргаж холбогдох байгууллагад хүргүүлэх	Улирал бүр	Шилэн дансны бүрэн хөтөлнө	О. Бишгарам Б. Бадамцэцэг
100	2.17.	Хурлын Төлөөлөгчдийн хувийн хэрэг шинээр бүрдүүлж, нэмэлт баяжилт хийнэ.	I улирал	Мэдээллийн сан бүрдэнэ.	О. Бишгарам

12

101	2.18	Хурлын Төлөөлөгчдийн танилцуулга самбар, Улаан загалмайн хорооны мэдээллийн самбар, Орон нутгийн хамгаалалтанд байгаа газар нутгийн тухай самбарууд шинээр хийнэ.	II улиралд	Иргэд мэдээлэл олж авах нөхцөл боломж бүрдэнэ.	Я.Очир О.Бишгарам
102	2.19	Сумын ИТХ-ын ажлын мэдээлэл, төлөөлөгчдийн танилцуулга, тогтоол шийдвэрийг вэиб сайтад бүрэн оруулж, мэдээллийн санг баяжуулна.	Тухай бүр	Мэдээллийн сан бүрдэж ил тод байдлыг хангана	О.Бишгарам
103	2.20	"Нутгийн удирдлага" сэтгүүлийн захиалгын тоог нэмэгдүүлж, НӨУБ-ын ажлын мэдээлэл, шинэ санаачлага, арга туршлагын талаар нийтлэл хэвлүүлж ажлаа сурталчилна.	2017 онд	улирал бүр 20-оос доошгүйг захиалуулна	Я.Очир О.Бишгарам

Төлөвлөсөн: Зорилт 2, Бүлэг 9, Нийт 103 ажил.

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА  О.БИШГАРАМ



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 03

Сэнхэр

Сонгуулийн хэсэг байгуулж, төвийг
зарлах тухай

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол улсын Ерөнхийлөгчийн 2017 оны ээлжит сонгуулийн санал авах, тоолох 4 хэсэг байгуулж, хэсгийн нутаг дэвсгэр, төвийг дараах байдлаар тогтоон зарласугай.

д/д	Хэсгийн төв	Нутаг дэвсгэр	Хэсгийн сонгогчдын тоо
1.	Улиастын бор үзүүр	Алаг баг	349
2.	Бортын бэлчир	Борт баг	345
3.	Их Хотгор	Хаг баг	231
4.	Сумын төв /соёлын төв/	Сэнхэр баг	435

2. Сонгуулийн нутаг дэвсгэр, хэсгийн төвийг иргэд, сонгогчдод сурталчилж, зарлан мэдээлэхийг сум, багийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тогтоолыг аймгийн Улсын бүртгэлийн хэлтэст 2017 оны 02 дугаар сарын 10-ны дотор хүргүүлэхийг сумын ЗДТГ-ын иргэний бүртгэлийн ажилтан Н.Эрдэнэхишигт үүрэг болгосугай.

ДАРГА  Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 04

Сэнхэр

Сумын сайн малчин шалгаруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.14 дахь заалт, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Сумын сайн малчин" шалгаруулах журмыг тус тус үндэслэн МЭҮТ-ийн дарга Б.Ганбатын өргөн мэдүүлсэн тодорхойлолтыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мал сүргээ жил бүр тогтвортой өсгөн үржүүлж, ашиг шимийг нэмэгдүүлэх, малыг эрүүлжүүлэх, бэлчээрийг хуваарьтай ашиглах, отор нүүдэл хийх ажилд баг, хамт олноо хошуучлан мал аж ахуйн салбарт өндөр үр бүтээлтэй ажиллаж байгаа амжилтыг нь үнэлэн Алаг багийн малчин Цэвээний Наранхүү, Давгын Эрэндаваа, Борт багийн малчин Батбаярын Болдхуяг, Чулуунбаярын Бямбадорж, Амгалангийн Буянтогтох, Хаг багийн малчин Ууганы Тамир, Жамбын Батжаргал, Сэнхэр багийн малчин Гаваагийн Мөнхзориг, Самдангийн Мөнхзандан, Уламбаярын Энхболд нарыг 2016 оны "Сумын сайн малчин"-аар шалгаруулсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 05

Сэнхэр

Төрийн дээд шагналд тодорхойлох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 05 дугаар сарын 07- ны өдрийн 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол одон, медалиар шагнах журам"-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Эдийн засаг, санхүүгийн салбарт тасралтгүй 47 жил үр бүтээлтэй ажиллахдаа санхүүгийн анхан шатны бүртгэл хөтлөлтийг сайжруулах, бүртгэлээр тавих хяналтын шинэ тогтолцоог нэвтрүүлж, нягтлан бодох бүртгэлийг олон улсын стандартын түвшинд хүргэж, эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, санхүүгийн сахилгыг бэхжүүлснээр өр авлагагүй байгууллагаар 6 удаа шалгарсан амжилтаар "Санхүү бүртгэлийн тэргүүний ажилтан", Ардын хувьсгалын 60,70,80,90 жилийн ойн медалиуд, "Хөдөлмөрийн хүндэт медалиудаар энгэрээ мялааж, өөрийн мэдлэг оюун, хүч хөдөлмөрөө улс эх орон, сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, их бүтээн байгуулалтанд зориулж ажилласныг өндрөөр үнэлэн тус сумын Сэнхэр багийн иргэн, ахмад нягтлан бодогч Шарав овогтой Балтавыг Монгол Улсын Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнуулахаар тодорхойлж уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 06

Сэнхэр

Төрийн дээд шагналд тодорхойлох тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.15 дахь заалт, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол Улсын цол одон, медалиар шагнах журам"-ыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Барилгын салбарт тасралтгүй 32 жил үр бүтээлтэй ажиллахдаа Баянхонгор аймгийн Шаргалжуутын амралтын газрын анхны модон барилга, Нэгдсэн эмнэлэг, Говь-Алтай аймгийн Халиун, Тайшир сумын сургуулийн хүүхдийн дотуур байр, Хүн эмнэлэг, Алтай сумын тэжээлийн агуулах, Ховд аймгийн I, IV арван жилийн сургууль, ХАА-н техникум, Хүнсний комбинат, Тоосгоны үйлдвэр, Ховд зочид буудал, 24, 36, 52 айлын орон сууцууд, Хөгжимт драмын театр, Наадмын цэнгэлдэх хүрээлэн, Төв номын сангийн барилга, Ховд аймгийн Мөнххайрхан сумын 4 айлын орон сууц, Халуун ус, Алаг, Борт бригадын төвийн барилгуудыг бариулахад гар бие оролцон барилгын техникч, бригадын ахлагчаар ажиллахдаа хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм журмыг чанд мөрдүүлж зөрчил дутагдалгүй ажиллаж, өөрийн мэдлэг оюун, авъяас чадвар, бүтээлч хөдөлмөрөө зориулан улс эх орон сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлт, их бүтээн байгуулалтанд үнэтэй хувь нэмэр оруулсан амжилтыг өндрөөр үнэлэн тус сумын Сэнхэр багийн иргэн, ахмад барилгачин Цомбог овогтой Бүрбаяаг Монгол Улсын Төрийн дээд шагнал "Алтан гадас одон"-гоор шагнуулахаар тодорхойлж уламжилсугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР



D; Togtool;2017.03.23



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 07

Сэнхэр

Санал дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалтыг үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдоос өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 6 хүн буюу хуралд оролцсон Тэргүүлэгчдийн 100 хувийн саналаар сумын Засаг даргын орлогчоор Цээрэвийн Ганболдыг томилуулахаар зөвшилцсөн саналыг дэмжсүгэй.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР





ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 08

Сэнхэр

Сумын 90 жилийн ой тэмдэглэх тухай

Монгол улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг нь мөнхжүүлэх журам"-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сум үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойг 2017 оны 7 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд сумын төвд тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг, хяналтын зөвлөл, салбар комиссын бүрэлдэхүүнийг байгуулах санал, ойн хүрээнд хийгдэх бүтээлч ажлын төлөвлөгөө боловсруулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулахыг сумын Засаг дарга Б.Батболдод даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 02 сарын 17 өдөр

Дугаар 09

Сэнхэр

Ой зохион байгуулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.17 дахь заалтын үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сум үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Б.Батболд	-Сумын Засаг дарга
Орлогч дарга:	Ц.Ганболд	-Сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ц.Тунгалаг	-Сумын ЗДТГ-ын дарга
	В.Батчулуун	-ЗДТГ-ын мэргэжилтэн
Гишүүдэд:	Б.Нямаа	-Ахмадын хорооны дарга
	С.Бүрнээ	-Сумын Засаг дарга асан
	С.Жимсээ	-Сумын Засаг дарга асан
	Ц.Бөхөө	-Сумын Засаг дарга асан
	С.Хүрэлтөмөр	-Сумын Засаг дарга асан
	Я.Хүрэлчулуун	-Сумын Засаг дарга асан
	Ш.Тогооч	-Төрийн сангийн төлөөлөгч
	Б.Түвшинзориг	-Сургуулийн захирал
	Д.Энхбулган	-Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
	У.Долгорсүрэн	-Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
	У.Даваажаргал	-Цаг уурын ахлах техникч
	М.Одхүү	-БЦГ-ын хамгаалалтын захиргааны даргын үүрэг гүйцэтгэгч
	Х.Мягмаржав	-Соёлын төвийн эрхлэгч
	Э.Эрэндаваа	-Уяачдын холбооны тэргүүн

Г.Түвшинтөр	-Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
Д.Маамбаа	-Бөхийн холбооны тэргүүн
Ч.Жаргалсайхан	-Сурын холбооны тэргүүн
Н.Азжаргал	-Алаг багийн Засаг дарга
Б.Хосзандан	-Хаг багийн Засаг дарга
В.Цогтоо	-Сэнхэр багийн Засаг дарга
	-Борт багийн Засаг дарга

2.Сумын 90-н жилийн ой зохион байгуулах ажлын хэсгийг шуурхай удирдлагаар хангаж, төлөвлөгөө хөтөлбөр гарган хэрэгжүүлж, үзэл суртлын өндөр хэмжээнд зохион байгуулж явуулахыг сумын Засаг дарга, ажлын хэсгийн ахлагч Б.Батболд, гишүүдэд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 02 өдөр

Дугаар 10

Сэнхэр

Ээлжит хуралдаан товлон зарлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 22 дугаар зүйлийн 22.1.1, 23 дугаар зүйлийн 23.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит 3 дугаар хуралдааныг 2017 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн "Пүрэв" гарагт сумын төвд хуралдуулахаар товлон зарласугай.

Хоёр. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 3 дугаар хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1/ Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016-2020 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөний тухай илтгэл

2/ Сумын Засаг даргын 2016-2020 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, 2017 онд сумын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн тухай илтгэл

3/ Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2017 оны батлагдсан төсөвт өөрчлөлт оруулах тухай илтгэл

4/ Сумын 90-н жилийн ойн төсвийн төслийн тухай илтгэл

Гурав. Хуралдаанаас гарах шийдвэрийн төслүүдийг боловсруулан бэлэн болгож, хуралдааны бэлтгэлийг хангаж зохион байгуулалт сайтай хуралдуулахыг нарийн бичгийн дарга /О.Бишгарам/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 11

Сэнхэр

Амьжиргаа дэмжих зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Нийгмийн халамжийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь заалт, Сумын Засаг даргын өргөн мэдүүлсэн саналыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Нийгмийн халамж үйлчилгээнд хамруулах эсэх талаар шийдвэр гаргах, халамжийн үйл ажиллагаатай холбогдсон гомдлыг хүлээн авч шийдвэрлэх үүрэг бүхий сумын амьжиргаа дэмжих зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга:	Ц.Ганболд	-Сумын Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	О.Алтансүвд	-Сумын Хөдөлмөр халамж үйлчилгээний мэргэжилтэн
Гишүүдэд:	Р.Цоож	-Сумын Нийгмийн даатгалын байцаагч
	Б.Хишиг	-Эрүүл мэндийн төвийн эмчлэгч их эмч
	Ж.Вааз	-Хаг багийн иргэн, ахмадын төлөөлөл
	Г.Мөнхтуул	-Сумын ЗДТГ-ын Нийгмийн ажилтан
	Б.Цэнгэл	-Алаг багийн иргэн, иргэний төлөөлөл

2.Амьжиргаа дэмжих зөвлөлийн ажлын тайланг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3.Тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 04 дүгээр тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР

D; Togtool;2017.03.09



ХОВД АЙМАГ
МӨНХХАЙРХАН СУМЫН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 12

Сэнхэр

Сумын 90-н жилийн ой зохион байгуулах ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 20.1.17 дахь заалтыг үндэслэн сумын Засаг дарга Б.Батболдын өргөн мэдүүлсэн саналыг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

Нэг .Мөнххайрхан сум үүсч хөгжсөний түүхт 90 жилийн ойн арга хэмжээг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралтаар, хяналтын зөвлөлийг 2 дугаар, салбар комиссыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр.Сумын Засаг дарга бөгөөд Ажлын хэсгийн ахлагч Б.Батболдод ДААЛГАХ нь:

1/Сумын 90 жилийн ойн төсөв, ой угтсан бүтээлч ажлын төлөвлөгөө, зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөнүүдийг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар батлуулах;

3/ Улаанбаатар хот, Ховд аймаг, бусад аймаг, хотуудад байгаа нутгийн зөвлөл, иргэдтэй уулзалт зохион байгуулах;

4/ Бүтээн байгуулалт, ойн арга хэмжээнд зориулан хөрөнгө оруулалт, төсөв бүрдүүлэх хандивын аян өрнүүлэх;

5/ Ой зохион байгуулах ажлын хэсэг, салбар комиссыг удирдлагаар хангаж, ажлын чиглэл, үүрэг даалгавар өгч ажиллах;

6/Ойн бэлтгэл ажлын явцын талаарх мэдээллийг 5 дугаар сард, хандивын зарцуулалт, ойн хүрээнд хийсэн ажлын тайланг 8 дугаар сарын 01-ны дотор ИТХ-ын Төлөөлөгчдөд танилцуулах;

Гурав. Ойн арга хэмжээний төсөв, хандивын зарцуулалт, ойн хүрээнд хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын явц, гүйцэтгэлд байнгын хяналт тавьж, төсвийн талаарх мэдээллийг сар бүр ИТХ-ын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг Хурлын дарга Я.Очир, хяналтын зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Я.ОЧИР

D; Togtool;2017.03.09


Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар сарын 09-ны
өдрийн 12 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт



СУМЫН 90 ЖИЛИЙН ОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ
АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Б.Батболд	-Сумын Засаг дарга
Орлогч дарга: Ц.Ганболд	-Сумын Засаг даргын Орлогч
Нарийн бичгийн дарга: О.Бишгарам	-Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
В.Батчулуун	-ЗДТГ-ын МЭҮТ-ийн мэргэжилтэн
Гишүүдэд: Б.Мөнхдорлиг	-Засаг даргын Тамгын газрын дарга
Ш.Тогооч	-Төрийн сангийн төлөөлөгч
Б.Нямаа	-Ахмадын хорооны дарга
Б.Ганбат	-МЭҮТ-ийн дарга
С.Бүрнээ	-Сумын Засаг дарга асан
С.Жимсээ	-Сумын Засаг дарга асан
Ц.Бөхөө	-Сумын Засаг дарга асан
Я.Хүрэлчулуун	-Сумын Засаг дарга асан
С.Хүрэлтөмөр	-Сумын Засаг дарга асан
Б.Түвшинзориг	-Сургуулийн захирал
Д.Энхбулган	-Эрүүл мэндийн төвийн эрхлэгч
У.Долгорсүрэн	-Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч
У.Даваажаргал	-Цаг уурын өртөөний ахлах техник
М.Одхүү	-БЦГ-ын хамгаалалтын захиргааны даргын үүрэг гүйцэтгэгч
Х.Мягмаржав	-Соёлын төвийн эрхлэгч
Э.Эрэндаваа	-Уяачдын холбооны тэргүүн
Г.Түвшинтөр	-Цагдаагийн хэсгийн төлөөлөгч
Д.Маамбаа	-Бөхийн холбооны тэргүүн
Ч.Жаргалсайхан	-Сурын холбооны тэргүүн
Н.Азжаргал	-Алаг багийн Засаг дарга
Б.Бөхболд	-Борт багийн Засаг дарга
Г.Ганболд	-Хаг багийн Засаг дарга
С.Мөнхтулга	-Сэнхэр багийн Засаг дарга

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 3 дугаар сарын 09-ны
өдрийн 12 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт



ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Зөвлөлийн дарга:	Я.Очир	- Сумын ИТХ-ын дарга
Гишүүдэд	Б.Цэнгэл	- Алаг багийн иргэн
